

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл Ажиллагааны Шинэчилсэн Мэдээ**

Петро Матад компани нь Монгол орны зүүн хэсэгт байрлах, Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт ("БХГ" гэх) Матад ХХ талбай дахь Давсан Толгой Төслийн үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

Шинэчилсэн мэдээлэлд:

- Давсан Толгой 11 ("ДТ-11" гэх) цооногийн туршилтын явцад тос гараагүй
- ДТ-11 цооногийн өрөмдлөгийн явцад илэрч, мэдээлэгдсэн тосыг одоогоор үлдэгдэл тос гэж үзэж байна
- Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн дагуу өрөмдсөн ДТ-1, ДТ-2 болон ДТ-3 цооногуудад ялгасан Цагаанцавын агуулагч давхаргаас илэрсэн тосыг мөн үлдэгдэл тос болохыг тогтоолоо.
- Давсан Толгойн оройгоос доод түвшинд, Давсан Толгойгоос салангид бүтэц дээр өрөмдсөн дөрвөн цооногт цаашид туршилт хийж, шингэн хагалбар гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна
- Өрөмдлөгийн хөтөлбөрөөр Матад ХХ талбайн газрын тосны системийн үндэс, суурийг тодорхойлсон бөгөөд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ
- Сейсмийн нарийвчилсан тайлалын тусламжтайгаар Давсан Толгойн хэмжээнд хэтийн төлөвтэй, хэтийн төлөв сайтай талбайдыг шинээр тогтоож, өмнө тогтоогдсон талбайдыг илүү нарийвчлан судалж байна
- 2011 оны 03 дугаар сарын 21-нд нийтэлсэн нөөцийн тооцоог энэ онд гүйцэтгэсэн өрөмдлөг, сейсмийн судалгааны хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан дахин хянаж, үр дүнг ирэх саруудад танилцуулна
- 2011 онд Матад ХХ талбайн зургаан дэд сав газарт гүйцэтгэсэн 2 хэмжээст сейсмийн судалгааны боловсруулалт, тайлалын ажил үргэлжлэн хийгдэж байна

ДТ-11 цооногийн туршилтын үр дүн

Компани Давсан Толгой 11 цооногийн ("ДТ-11" гэх) туршилтын ажлын үр дүнгийн үнэлгээг хийж дуусгалаа.

Анх ДТ-1 цооногт ялгасан үндсэн агуулагч давхаргыг турших зорилгоор, ДТ-1 цооногийг ДТ-11 цооноогоор орлуулан өрөмдсөн. Цооногийн цементийн барьцалдах чанар хангалтгүй байснаас судалгааны үндсэн хэсэг болох Дээд Цагаанцавын дээд хэсэгт формацийн эвдрэл үүссэний улмаас ДТ-1 цооногийг таглаж, битүүмжилсэн.

Дээд Цагаанцавын формацийн дээд хэсгийн 1,076-1,084 метрт байгаа судалгааны үндсэн хэсэг, 1,127-1,134 метр болон 1,100-1,103 метрт байгаа судалгааны хоёрдагч хэсгүүдэд туршилт хийгдсэн. Судалгааны хоёрдагч хэсгүүдийн нэвчүүлэмж бага, зөвхөн бага хэмжээний ус ялгарсан. Судалгааны үндсэн хэсгээс 2 удаагийн зогсолттойгоор 4 өдөр туршилт хийж, өдөрт дунджаар 525 баррель ус олборлосон. Дээрхи үр дүн нь эвдрэлийн улмаас үндсэн тосоо алдаж дуусаад, зөвхөн үлдэгдэл тосоо хадгалж үлдсэн тосны ордын формациас гарсан усны олборлолтын хэмжээтэй дүйж байна.


ДТ-11 цооногийн өрөмдлөгийн явцад Дээд Цагаанцавын формацийн дээд хэсгийн 1,074 метрт тосны илрэл тогтоогдсон. Тус цооногийн 1,078.6-1,083.4 метрээс авсан чөмөг дээж нь

нүүрсустөрөгчийн хурц үнэртэй, тосны урсацтай, флюоресценц бүхий тосны ул мөртэй элсэн чулуунаас бүрдэнэ. Петрофизикийн анхны шинжилгээгээр тус үеийн нүүрс устөрөгчийн ханалт 50 хувьтай тогтоогдсон хэдий ч дараагийн туршилтуудаар шилжилт хийгдээгүй үлдсэн тос болох нь тогтоогдсон. ДТ-11 цооногоос илэрсэн тосны ул мөр болон үлдэгдэл тосыг Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн дагуух бүтцийн болон давхаргазүйн хураагуурт үүссэн байсан тосны орд эвдэрлийн улмаас хөдөлгөөнт нүүрсустөрөгчөө алдагдсанаас үлдсэн үлдэгдэл хэмээн тодорхойлж байна.

ДТ-11 цооног болон Давсан Толгойн оройн дагуух ДТ-1, ДТ-2, ДТ-3 цооногуудын хоорондын харилцан хамаарал

ДТ-11 цооногийг ДТ-1 цооногоос урагш 225 метрт, ДТ-2 цооногоос хойш 712 метрийн зайд өрөмдсөн. Эдгээр гурван цооног нь Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн дагуух бие даасан, салангид бүтцийн хураагуур дотор орших бөгөөд цооногуудын судалгааны үндсэн хэсэг нь Дээд Цагаанцавын дээд хэсэг байсан. Цооногууд петрофизикийн шинж чанараараа ижил байсан нь энэхүү бүтцийн хураагуурт үлдэгдэл буюу үйлдвэрлэлийн үр ашиггүй, ханалт багатай нүүрсустөрөгч байсан болохыг ДТ-11 цооногийн туршилтын үр дүн нотоллоо. ДТ-3 цооногийн туршилтын үр дүн болон ДТ-11 цооногийн туршилтын үр дүнг нэгтгэн үзвэл хураагуурын эвдрэл нь Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн дагуух бүтцийн болон давхаргазүйн хураагууруудад нөлөөлсөн болох нь харагдаж байна. Цаашид ДТ-1, ДТ-2 болон ДТ-11 цооногуудад туршилтын ажил хийгдэхгүй. Харин ДТ-3 цооногийн 750-765 метрт байгаа Дээд Зүүнбаянгийн формацийн үеийг цаашид туршиж үзэх боломжтой.

Давсан Толгойн хэмжээнд хийх дүгнэлт



Давсан Толгойн хэтийн төлөв сайтай (prospect), хэтийн төлөвт талбайнууд (play) болон цооногууд

Давсан Толгойд өрөмдсөн цооногууд болон бусад мэдээллийг харуулсан бүдүүвч зургийг Компанийн цахим хуудсанд тавигдсан Шинэчилсэн мэдээллийн хуулбараас харж болно.

Давсан Толгойд гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүн, Давсан Толгойд гүйцэтгэсэн 3 хэмжээст сейсмийн дахин боловсруулалт нь нийт Давсан Толгой дахь нүүрсустөрөгчийн хураагуурын түүхийн тайлалыг дахин хянаж, сайжруулахад дөхөм боллоо. Манай талбайтай хойгуураа хиллэдэг XIX талбайн Тосон Уулын ордыг дайрсан 30 км урт бүтцийн урд үзүүр нь Давсан Толгойн гүдэн бүтэц юм. XIX талбайд үйл ажиллагаа явуулдаг Петро Чайна компанийн салбар Дачин Тамсаг Монголиа компани тус талбайг 1.2 тэрбум баррелийн геологийн нөөцтэйг мэдэгдсэн.

ДТ-1, ДТ-2, ДТ-3 болон ДТ-11 цооногуудаас авсан үйрмэг, чөмөг дээжин дэх үлдэгдэл нүүрсустөрөгчийн ханалт нь анх Тосон Уулын ордод тос хуримтлагдахтай ойролцоо үед Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн хэсэг рүү тос шилжиж, хуримтлагдсан болохыг нотолж байна. Харин Тосон Уулын орд хангалттай гүнд булагдсан байсан бол Давсан Толгойн гүдэн бүтэц сүүлд өргөгдлийн нөлөөгөөр харьцангуй гүехэн булагдсан байна. Энэхүү өргөгдөл нь гүдэн бүтцийн оройн дагуух хагарлын дахин идэвхижилттэй хавсран хуримтлагдсан нүүрсустөрөгчийг зайлуулсан байна.

Давсан Толгойн гүдэн бүтэц нь Матад ХХ талбайн хойд бүсийн тосны шилжилтийн үндсэн хэсэг гэж үзэж байсан тул 2010-2011 оны өрөмдлөгийн хөтөлбөрөөр тус гүдэн бүтцийн оройн дагуу ялгасан хэтийн төлөв сайтай талбайдыг өрөмдөж, турших зорилготой байсан. Монголын газрын тосны салбарын хөгжлийн хоцрогдолтой холбоотой материал, техникийн хангамжийн бэрхшээлээс шалтгаалан дээрхи цооногуудын туршилтын ажил 2011 оны хоёрдугаар хагас хүртэл хойшлогдсон.

Давсан Толгойн гүдэн бүтцийн оройгоос доод түвшинд өрөмдсөн цооногууд, мөн түүнчлэн бусад бүтцүүд дээр илүү гүнд өрөмдсөн цооногуудын үр дүн ДТ-1, ДТ-2, ДТ-3 болон ДТ-11 цооногуудаас нилээд ялгаатай байлаа. Нэгдүгээрт, хагарлууд нь их хэмжээний даралтаар илүү гүнд, сайтар битүүмжлэгдсэн учир агуулагч давхаргууд нь эвдэрч, шүүрэлгүйгээр тосоо хадгалж үлдсэн байна. Гүн өрөмдсөн цооногуудаас ялгарсан тос нь хөнгөн бөгөөд ДТ-8 цооноогоос гарсан тосны API үзүүлэлт 32°, ДТ-4 цооногийнх 42° байсан.


Хураагуурын хормойд /бэлд/ өрөмдсөн цооногуудын агуулагч давхаргын шинж чанар нь Тосон Уул ордын Цагаанцавын агуулагч давхаргатай ижил байгааг харуулж байна. Тосон Уулын ихэнхи цооногуудад үйлдвэрлэлийн олборлолт хийх зорилгоор шингэн хагалбар хийх шаардлагатай байдаг.

2012 оны хээрийн ажил ажил эхлэх үед ДТ-4, ДТ-5, ДТ-7 болон ДТ-8 цооногуудад туршилт, хагалбар зэргийг гүйцэтгэхээс гадна тэдгээрийн ойролцоо шинээр цооног өрөмдөхөөр төлөвлөөд байна.

Давсан Толгойн 3 хэмжээст сейсмийн дахин боловсруулалтын үр дүнгээр Давсан Толгойн гүдэн бүтцийн баруун болон зүүн захаар илүү гүнд орших хэтийн төлөв сайтай талбайдыг ялгасан бөгөөд эдгээр талбайдын хураагуурын үүсэл, одоогийн гүн, хагарлын түүх зэрэг нь Тосон Уулын ордод байгаа нь нэгэнт батлагдсан хураагууруудтай ижил төстэй байна. Дахин боловсруулсан мэдээллийн давхаргазүйн нарийвчлалыг сайжруулсаны үр дүнд Дээд Цагаанцавын дээд хэсэг болон Доод Цагаанцавын нүүрсустөрөгч хуримтлуулах системийг ялгасан бөгөөд тэдгээрийг мөн хэтийн төлөв сайтай талбайн зэрэглэлд хамааруулах боломжтой эсэхийг нарийвчлан судалж байна.

Дээр дурдсан дахин боловсруулалт, тайлалыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, хэтийн төлөвтэй(leads) болон хэтийн төлөв сайтай(prospects) талбайдын бүртгэлийг шинэчлэн Давсан Толгойн болон Том Давсан Толгойн эзэлхүүн, таамаг нөөцийг тооцоход ашиглана.

Матад ХХ талбайн хайгуулын ажилд үзүүлэх нөлөө



Матад ХХ талбайн дэд сав газрууд болон геофизикийн судалгааны хөтөлбөр

Компанийн цахим хуудсанд тавигдсан энэхүү Шинэчилсэн мэдээллийн хуулбараас Матад ХХ талбайн техникийн мэдээлэлтэй танилцаж болно.

Петро Матадын 2010/2011 оны өрөмдлөгийн хөтөлбөрийг 2008 онд 3 хэмжээст сейсмийн судалгаа хийсэн Том Давсан Толгойн 133 км² талбайд гүйцэтгэсэн бөгөөд Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн хэсгийг судлахад чиглэгдсэн. 3 хэмжээст сейсмийн судалгаа хийгдсэн хэсэг нь Матад ХХ талбайн 1.2 хувьтай тэнцэнэ. Урьд нь хийгдсэн 2 хэмжээст сейсмийн судалгаагаар Давсан Толгойн ойр орчимд буюу Матад ХХ талбайн үлдсэн 10,340 км² талбайд хэтийн төлөвтэй болон хэтийн төлөв сайтай өөр талбайнууд, мөн түүнчлэн тусдаа дэд сав газруудыг ялгасан.

Хэдийгээр Матад ХХ талбайн хойд хэсгийн бүтцийн болон давхаргазүйн хураагуурын элементүүд нь өрөмдлөгийн өмнө бидний тооцоолж байснаас илүү нарийн төвөгтэй байсан ч бид Давсан Толгойн цооногуудад хийсэн туршилтын үр дүнд Тамсагийн сав газрын өмнөд хэсгийн газрын тосны системийн үндсэн элементүүдийн талаархи мэдлэгээ батжуулж чадлаа. Эдгээрээс олон элементүүдийг Матад ХХ талбайн үлдсэн хэсгийн элементүүдтэй дүйцүүлж болно. Тухайлбал:

- Давсан Толгойд өрөмдсөн бүх цооногуудын Зүүнбаян болон Цагаанцавын үеүүдэд элсэн чулуун агуулагч давхарга байгаа нь илэрсэн

- Давсан Толгойд өрөмдсөн бүх цооногуудаас өндөр чанарын тос үүсгэгч чулуулаг илэрсэн бөгөөд тэдгээр нь сейсмийн судалгааны үр дүнгээс харахад Матад ХХ талбайн бүх дэд сав газруудад хамааралтай болох нь харагдлаа.
- Давсан Толгойд өрөмдсөн цооногуудын дулааны шатлалын дундаж нь с.33С/км байгаа нь нүүрсустөрөгчийн үүсэл 2 км-ийн гүнд эрт явагдаж, өнөө үед с.3км-ээс доош гүнд нүүрсустөрөгч үүсч буй боломжтойг харуулж байна. Тосны шилжилт нүүрсустөрөгч үүсэх гал зуухны захаас сав газрын захад үүссэн хураагуур хүртэл нилээд хол зайнд (10 км хүртэл) явагдсаныг ДТ-1, ДТ-2, ДТ-11 болон ДТ-3 цооногуудаас илэрсэн тосны илэрц нотолж байна.
- ДТ-8 болон ДТ-4 цооногуудын гүехэн хэсгээс эхлэн дунд зэргийн гүнд байгаа сав газрын хураагуурт хөнгөн болон өндөр чанарын тос илэрсэн. Жич – ДТ-1 цооногоос илэрсэн тосны анхны шинжилгээгээр API үзүүлэлт нь 21° байсан ч дараагийн шатны шинжилгээгээр API үзүүлэлт 25°-30° болсон.

Петро Матад компани Матад ХХ талбайд давхаргазүйн хувьд нүүрс устөрөгчийн хангалттай хэмжээний хуримтлал үүсэх боломжтой дөрвөн дэд сав газрыг шинээр тогтоосон. Тэдгээрээс XIX талбай дахь хоёр дэд сав газар (Тосон Уул, Зүүн Тосон Уул) үйлдвэрлэлийн үр ашигтай гэж батлагдсан хэдий ч тэдгээрийн Матад ХХ талбайд үргэжлэх хэсэгт өрөмдөж, судалгаа хийгдээгүй.

Нийт зургаан сав газраас зөвхөн Тосон Уул болон өмнөд Шорвогийн сав газарт 2011 оноос өмнө 3,189 тууш км-ийг хамарсан 2 хэмжээст сейсмийн судалгаа хийгдсэн.

2011 оны эхний хагаст гүйцэтгэсэн 1,256 тууш км-ийн 2 хэмжээст сейсмийн судалгаа нь Матад ХХ талбайд бүтнээрээ багтдаг Асгат, Эрдэнэцагаан, зүүн Эрдэнэцагааны сав газруудыг судлахад чиглэгдсэн. Компанийн 2007 онд гүйцэтгэсэн 6,141 цэгийн хүндийн хүчний хэмжилтийг нэмэгдүүлэхээр энэ онд 4000 цэгийн хүндийн хүчний хэмжилтийг Асгат болон Эрдэнэцагааны ховдлуудад эхлүүлээд байна.

XIX талбайн Зүүн Тосон Уулын дэд сав газар нь Матад ХХ талбайтай зэрэгцээ оршдог бөгөөд Давсан Толгойн зүүн хэсгээр үргэлжилдэг. Энэхүү хэсэгт 2011 онд 2 хэмжээст сейсмийн нэмэлт судалгаа хийсэн бөгөөд одоогоор судалгааны боловсруулалт, зураглалын ажил хийгдэж байна.

Петро Матад компани 2011 оны 2 хэмжээст сейсмийн мэдээлэл, 2011 оны 3 хэмжээст сейсмийн дахин боловсруулсан мэдээллийг 2011 оны өрөмдлөгийн үр дүн, одоогийн хүндийн хүчний судалгаа болон 2 хэмжээст сейсмийн мэдээллийн сантай нэгтгэж, Матад ХХ талбайн бүх дэд сав газруудыг бүхлээр нь хамарсан нөөцийг тодорхойлохоор ажиллаж байна.

Петро Матад компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй ДТ-11 цооногийн туршилтын үр дүнг дүгнэж хэлэхдээ “ДТ-11 цооногийн туршилтаар Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн хэсэгт үйлдвэрлэлийн ач холбогдолтой тос илрээгүй нь харамсалтай. Гэхдээ судалгаанд хамрагдсан хэтийн төлөв сайтай талбайн оройн хэсэг нь Давсан Толгойн зөвхөн нэг хэсэг бөгөөд энэхүү хэтийн төлөв сайтай талбайн бусад хэсгүүдэд судалгаа хийх боломжтойг дурдах нь зүйтэй. Түүнчлэн Давсан Толгойн ойр орчимд цаашид нарийвчлан судлах талбайнууд бий бөгөөд Матад ХХ талбайн бусад сав газруудыг ирээдүйтэй нүүрсустөрөгч хуримтлуулах систем болгохоор судалж байна.”

“Компани эдгээр үр дүнгүүдийг Матад ХХ талбайд төлөвлөгөөтэй, дэс дараалалтайгаар гүйцэтгэж буй хайгуулын ажлын нэг хэсэг гэж үзэж байна. Гүдэн бүтцийн оройн хэсэгт үйлдвэрлэлийн ач холбогдолтой тос байхгүйг баталсан хэдий ч өсөн нэмэгдэж байгаа хайгуулын ажлын эерэг үр дүнд сэтгэл хангалуун байна.”

“Ди Кью И Интернэшнл компани 2012 онд манай өрөмдлөгийг цаг алдалгүй үргэжлүүлэх боломжтойгоор өрмийн болон цооногийн үйлчилгээний цамхагуудаа Компанийн талбайд үлдээсэн. Компани шингэн хагалбарын ажил гүйцэтгэгч олон улсын компанитай холбоо тогтоож, гэрээ хэлэлцээрийг амжилттай хийсэн. Шингэн хагалбарын ажлыг одоогоор түр зогсоосон бөгөөд 2012 оны өвлийн түр зогсолтын дараа өрөмдсөн цооногуудаасаа сонгож шингэн хагалбарыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.”

“Бид цаашид Компанийн дахин тооцсон нөөц, Давсан Толгой болон түүний ойр орчмын шинэчилсэн зураглал, Матад ХХ талбайн хэтийн төлөв сайтай бусад олон талбайнуудад хийсэн 2 хэмжээст сейсмийн ажлын үр дүнг багтаасан 2011 оны хайгуулын хөтөлбөрийн нэгдсэн тайланг хувь нийлүүлэгчид болон үнэт цаасны зах зээлд танилцуулах болно.”

“Манай хайгуулын ажлын үр дүн болон тус бүс нутагт манайтай ижил төрлийн сав газраас тосны олборлолтыг амжилттай явуулж байгаа зэргийг харгалзан үзвэл бидний хайгуулын ажил цаашид амжилттай үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна.”

“2011 оны хайгуулын хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн бусад судалгааны үнэлгээ, тайлангийн ажлууд хийгдэж байна. Тухайлбал, Богд IV, Онги V талбайнуудын хээрийн судалгааны ажил дуусах шатандаа орсон бөгөөд бид цаашид хувь нийлүүлэгчиддээ дээрхи хоёр талбайд хийгдсэн ажлуудын үр дүн, дүгнэлтийг мэдээлэх болно.” гэлээ.

Энэхүү мэдээлэлд тусгагдсан шинжилгээний үр дүнгийн мэдээллүүдийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрладаг Амбэр ХХК-ний магадлан итгэмжлэгдсэн лабораториас авав.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспект Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1 И Кью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед

Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед

Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100